



2018 оны 01 дүгээр сарын 29  
№04/1009/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын  
хууль**

**Агаарын тухай хуульд нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай**

**Монгол Улсын  
Их Хурлын  
тогтоол**

**Агаарын бохирдлыг  
бууруулахтай холбогдуулан  
авах арга хэмжээний тухай**

**Монгол Улсын  
Их Хурлын  
тогтоол**

**Нэмэгдлийн хэмжээ  
тогтоох тухай**

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

41.	Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	142
42.	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	143
43.	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	144
44.	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай	145
45.	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай	145

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

46.	Хуулийн төслүүдийг буцаах тухай	Дугаар 01	146
47.	Агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай	Дугаар 02	146
48.	Нэмэгдлийн хэмжээ тогтоох тухай	Дугаар 03	149

### МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

49.	Үндсэн хуулийн цэцийн тогтоолоор хүчингүй болсон Шүүх байгуулах тухай хуулийн заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн эсэх маргааныг хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн тухай	Дугаар 01	150
-----	---	-----------	-----



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 01 дүгээр  
сарын 12-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АГААРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Агаарын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг нэмсүгэй:

#### **1/15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсэг:**

“15.7. Аймаг, нийслэлийн Засаг дарга агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах, хэрэгжилтийг тайлагнах үүрэг бүхий албыг байгуулж ажиллуулна.”

#### **2/29<sup>1</sup> дүгээр зүйл:**

##### **“29<sup>1</sup> дүгээр зүйл. Агаарын бохирдлын эсрэг сан**

29<sup>1</sup>.1. Агаарын бохирдлын эсрэг сан /цаашид “сан” гэх/-гийн үйл ажиллагааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар<sup>1</sup> зохицуулна.

29<sup>1</sup>.2. Сангийн төсвийн ерөнхийлөн захирагч нь байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

29<sup>1</sup>.3. Сан нь түүний үйл ажиллагааг удирдан чиглүүлэх орон тооны бус Удирдах зөвлөлтэй байна.

29<sup>1</sup>.4. Энэ хуулийн 29<sup>1</sup>.3-т заасан Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхий сайд томилно.

29<sup>1</sup>.5. Энэ хуулийн 29<sup>1</sup>.3-т заасан Удирдах зөвлөлийн ажиллах журмыг Засгийн газар батална.”

**2 дугаар зүйл.** Агаарын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “мэргэжлийн алба” гэснийг “бүх шатны Засаг дарга мэргэжлийн албатай хамтран” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**

**Л.ЭНХ-АМГАЛАН**

<sup>1</sup> Засгийн газрын тусгай сангийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2006 оны 27 дугаарт нийтлэгдсэн.



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 01 дүгээр  
сарын 12-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь зүйл, заалт нэмсүгэй:

**1/5 дугаар зүйлийн 5.4.42 дахь заалт:**

“5.4.42.Агаарын бохирдлын эсрэг сан.”

**2/6 дугаар зүйлийн 6.4.24 дэх заалт:**

“6.4.24.Агаарын бохирдлын эсрэг сан.”

**3/12<sup>2</sup> дугаар зүйл:**

**“12<sup>2</sup> дугаар зүйл.Агаарын бохирдлын эсрэг сан**

12<sup>2</sup>.1.Агаарын бохирдлын эсрэг сангийн хөрөнгө нь энэ хуулийн 7.1-д зааснаас гадна дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

12<sup>2</sup>.1.1.агаарын бохирдлын төлбөрийн орлого 100 хувь, нөхөн төлбөр;

12<sup>2</sup>.1.2.бусад орлого.

12<sup>2</sup>.2.Энэ хуулийн 12<sup>2</sup>.1-д заасан сангийн хөрөнгийг доор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

12<sup>2</sup>.2.1.агаарыг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэхэд хөнгөлөлттэй зээл олгох;

12<sup>2</sup>.2.2.стандартын шаардлагад нийцсэн цэвэр түлш, зуух үйлдвэрлэхийг дэмжих, тэдгээрийг худалдан авахад хөнгөлөлт үзүүлэх;

12<sup>2</sup>.2.3.стандартын шаардлагад нийцсэн бүрэн шаталттай зуухны техник, технологийг нэвтрүүлэх, ашиглахад дэмжлэг үзүүлэх;

12<sup>2</sup>.2.4.агаарын чанарын хяналт-шинжилгээний чадавхыг бэхжүүлэх, хэмжилтийн багаж төхөөрөмж худалдан авах, агаарын чанарын төлөв байдлын хувьсал өөрчлөлтийг судлан тогтоох болон агаарыг хамгаалахтай холбоотой стандарт, норм, дүрэм, арга, аргачлал боловсруулах, судалгаа, шинжилгээний төсөл, ажлыг гүйцэтгэх;



12<sup>2</sup>.2.5.эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, барилгын дулаан алдагдлыг бууруулах, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, эдийн засгийн үр ашигтай, найдвартай ажиллагааг хангасан эрчим хүчний шинэ эх үүсвэр барих, хэрэглэгчийг төвлөрсөн дулаанд холбох төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

12<sup>2</sup>.2.6.агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн иргэд, олон нийтийн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх;

12<sup>2</sup>.2.7.сэргээгдэх эрчим хүч, цэвэр технологийг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх;

12<sup>2</sup>.2.8.агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн олон нийтэд мэдлэг олгох сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулах;

12<sup>2</sup>.2.9.уул уурхайн орчны бохирдлыг арилгах, хүн амд үзүүлж байгаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай ажлыг санхүүжүүлэх, дэмжлэг үзүүлэх.

12<sup>2</sup>.3.Энэ хуулийн 12<sup>2</sup>.2.1-д заасан хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журмыг санхүү, төсвийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**

**Л.ЭНХ-АМГАЛАН**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2018 оны 01 дүгээр  
сарын 12-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **АГААРЫН БОХИРДЛЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсгийн “улсын төсөвт” гэснийг “Агаарын бохирдлын эсрэг санд” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**

**Л.ЭНХ-АМГАЛАН**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2018 оны 01 дүгээр  
сарын 12-ны өдөр

Улаанбаатар  
хот

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН  
ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах, агаарын чанарыг сайжруулах зорилгоор импортоор оруулж байгаа агаар цэвэршүүлэгч, эрчим хүчний хэмнэлттэй халаагч төхөөрөмжийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсүгэй.

**2 дугаар зүйл.**Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх агаар цэвэршүүлэгч, халаагч төхөөрөмжийн жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/”-ийн ангиллын дагуу Монгол Улсын Засгийн газар батална.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**

**Л.ЭНХ-АМГАЛАН**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2018 оны 01 дүгээр  
сарын 12-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах, агаарын чанарыг сайжруулах зорилгоор импортоор оруулж байгаа агаар цэвэршүүлэгч, эрчим хүчний хэмнэлттэй халаагч төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлсүгэй.

**2 дугаар зүйл.**Гаалийн албан татвараас чөлөөлөх агаар цэвэршүүлэгч, халаагч төхөөрөмжийн жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/”-ийн ангиллын дагуу Монгол Улсын Засгийн газар батална.



**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**

**Л.ЭНХ-АМГАЛАН**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 01 дүгээр  
сарын 05-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар  
хот

**Хуулийн төслүүдийг буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Ө.Энхтүвшин нарын 10 гишүүнээс 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи хэлэлцэх боломжгүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 01 дүгээр  
сарын 05-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар  
хот

**Агаарын бохирдлыг бууруулахтай  
холбогдуулан авах арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Агаарын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын даргын 2017 оны 212 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан дараахь арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т үүрэг болгосугай:

1/Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2017 оны 03-03 дугаар зөвлөмж, Монгол Улсын Их Хурлын агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооны 2016 оны 01 дүгээр, 2017 оны 01 дүгээр тогтоолын хэрэгжилтийг Улсын Их Хуралд 2018 оны 02 дугаар сарын 01-ний дотор танилцуулах;

2/нийслэл болон төвлөрсөн суурин газрын агаарын бохирдлыг бууруулах, утааг багасгах асуудлыг тухайлан хариуцах төрийн захиргааны бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох, шаардлагатай тохиолдолд тухайн асуудлыг хариуцсан байгууллага байгуулах эсэх асуудлыг судалж, шийдвэрлэх, агаар орчныг бохирдуулж байгаа асуудалд хариуцлагын тогтолцоог цогц тодорхой тусгасан шинэ хуулийн төсөл, холбогдох бусад хууль тогтоомжид өөрчлөлт оруулах хууль, тогтоолын төслийг 2017 оны намрын чуулганы хугацаанд боловсруулж, өргөн мэдүүлэх;

3/Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор нийслэлээс орон нутаг руу ажиллаж амьдрах иргэдийн санал санаачилгыг дэмжих бодлого боловсруулан хэрэгжүүлэх, аян өрнүүлэх, дагуул хотуудыг бий болгож шинжлэх ухаан, технологи, инноваци, аялал жуулчлал, аж үйлдвэр, худалдааны чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлэх, төрийн зарим байгууллага болон төрийн өмчит их, дээд сургуулийг хотоос гаргах, тэдгээрийг холбосон хурдны зам, метро байгуулах урьдчилсан тооцоо судалгаа хийж, нийслэл хотын зарим чиг үүргийг аймгийн зэрэглэлтэй болон дагуул хот руу шилжүүлэх зэрэг асуудлыг 2018 оны 1 дүгээр улиралд багтаан судалж, холбогдох шийдвэрийг гаргах;

4/төсвийн байгууллагын халаалтын нам даралтын зууханд улсын төсвийн хөрөнгөөр, хувийн аж ахуйн нэгж, байгууллагад урт хугацааны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр технологийн шинэчлэл хийх ажлыг 2018 оноос эхлүүлэх, тэдгээрийн хэрэглэгчдийг төвийн эрчим хүчний системд холбох, сэргээгдэх эрчим хүч, хийн түлшинд шилжүүлэх замаар түүхий нүүрсний хэрэглээг багасгах асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэж Улаанбаатар хотод байгаа түүхий нүүрсээр ажилладаг





халаалтын нам даралтын зуухнуудыг 2019 оноос хаах, чанар стандартын шаардлага хангасан утаагүй шахмал болон хийн түлшний үйлдвэрлэл эрхлэгчдийг төрийн оновчтой бодлогоор дэмжих, зохист хэмжээнээс их хорт утаа ялгаруулж байгаа авто тээврийн хэрэгсэл, зориулалтын бус түлш хэрэглэн химийн хорт бодис ялгаруулж агаарын чанар, нийгмийн эрүүл мэндэд хохирол учруулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг чангатгаж, таслан зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

5/гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг эрчимжүүлэх, гэр хорооллын дэд бүтцийг бий болгож, төвлөрсөн дулаан хангамжид холбох, аймгийн төвүүд болон Улаанбаатар хотод баригдаж бэлэн болсон, зах зээл дээр борлогдоогүй байгаа орон сууцны тооцоолол судалгааг нарийвчлан гаргаж, тэдгээрт гэр хорооллын иргэдийг оруулах талаар арилжааны банкууд, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран судалж, 2018 оны эхний хагас жилд багтаан холбогдох шийдвэрийг гаргах;

6/агаарын бохирдлыг бууруулах, агаарын бохирдлоос иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн үндэсний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, импортлох, олон улсын дэвшилтэт техник технологийг хэрэглээнд нэвтрүүлэх талаар иргэн, аж ахуйн нэгж, иргэний нийгмийн байгууллагаас гаргасан аливаа санал санаачилга, үйл ажиллагааг төрийн бодлогоор дэмжиж, татварын болон санхүүгийн бодитой дэмжлэг үзүүлэх, хөнгөлөлттэй зээл тусламжид хамруулах, хотын ногоон байгууламжийг өргөтгөх, хог хаягдлын менежментийг сайжруулах;

7/агаарын бохирдлоос хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах, урьдчилан сэргийлэх хүрээнд улсын хэмжээнд сургуулийн өмнөх, ерөнхий болон мэргэжлийн боловсрол, дээд сургуулийн хичээлийн жил эхлэх, дуусах болон улирлын амралтын хуваарийг өөрчлөх асуудлыг судалж, 2018 онд багтаан шийдвэрлэж, хэрэгжүүлэх.

2.Тогтоолын биелэлтийн явцыг тухайн жилийн улирал тутам Байгаль орчин, хүнс, хөдөө, аж ахуйн болон Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд, тогтоолын хэрэгжилтийн талаар 2018 оны дөрөвдүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т чиглэл болгосугай.



3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө, аж ахуйн байнгын хороо /Л.Элдэв-Очир/, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо /Ё.Баатарбилэг/-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 01 дүгээр  
сарын 12-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар  
хот

### **Нэмэгдлийн хэмжээ тогтоох тухай**

Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ахмад дайчин, ардын цолтон ахмад настанд олгох нэмэгдлийн хэмжээг 200,000 /хоёр зуун мянга/, Монгол Улсын төрийн шагналт, төрийн соёрхолт, гавьяат цолтон, Улсын ударник, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, Монгол Улсын Үндсэн хуулийг хэлэлцэж, баталсан /1990-1992 он/ Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн ахмад настанд олгох нэмэгдлийн хэмжээг 150,000 /нэг зуун тавин мянга/ төгрөгөөр тус тус тогтоосугай.

2.Энэ тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.

3.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Төрөөс олгох нэмэгдлийн хэмжээ тогтоох тухай /Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын цолтон ахмад настан, гавьяат цолтон ахмад настанд төрөөс олгох нэмэгдлийн хэмжээ/” Улсын Их Хурлын 2008 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 33 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



4.Монгол Улсын Үндсэн хуулийг хэлэлцэж, баталсан 1990-1992 оны Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн ахмад настанд Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн 10.2-т заасан хугацаанаас эхлэн нэмэгдлийг олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ**

2018 оны 01 дүгээр  
сарын 17-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар  
хот

**Үндсэн хуулийн цэцийн тогтоолоор хүчингүй  
болсон Шүүх байгуулах тухай хуулийн заалтыг  
агуулгаар нь дахин сэргээсэн эсэх маргааныг  
хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн  
хуралдааны танхим 11.00 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Жанцан, Т.Лхагваа /илтгэгч/, Ш.Цогтоо, Д.Сугар, Н.Чинбат, Д.Наранчимэг, Д.Солонго нарын бүрэлдэхүүнтэй хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн С.Номынбаясгалан оролцож, Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж гадаад улсад албан ёсны айлчлалтай байсан тул оролцоогүй болно.

Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 5 дугаар сарын 13-ны өдөр өөрчлөлт оруулсан Шүүх байгуулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн “Нэг.

Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх” гэсэн хэсгийн 8 дахь заалтад “Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх” гэж, мөн “Хоёр.Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх” гэсэн хэсгийн 8 дахь заалтад “Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх” гэж тус тус хуульчилсан нь Үндсэн хуулийн цэцийн тогтоолоор хүчингүй болсон Шүүх байгуулах тухай хуулийн холбогдох заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн эсэх тухай маргааныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн хяналтын журмаар хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 7 дугаар хорооны оршин суугч, иргэн С.Номынбаясгалан Үндсэн хуулийн цэцэд хандаж дараах агуулга бүхий мэдээллийг ирүүлсэн байна. Үүнд:

“Монгол Улсын Их Хурлаас 2016 онд оруулсан өөрчлөлтөөр Шүүх байгуулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн Нэг дэх хэсгийн 8 дахь заалтад “Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх” гэж, мөн зүйлийн Хоёр дахь хэсгийн 8 дахь заалтад “Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх” гэж тус тус хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх ...” гэсэн хэсгийг зөрчиж байна. Монгол Улсын шүүхийн үндсэн тогтолцоог тойргийн зарчмаар бус, харин нутаг дэвсгэрийн харьяаллын зарчмаар зохион байгуулахаар тусгасан болно.” гээд Шүүх байгуулах тухай хуулийн холбогдох заалтыг хүчингүй болгосон Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 02 дугаар тогтоол, 2015 оны 01 дүгээр тогтоол, 2016 оны 01 дүгээр тогтоолыг иш татан дурдаж, “Багахангай, Налайх дүүргүүдийн дунд Иргэний болон Эрүүгийн хэргийн анхан шатны нэг, нэг шүүх байгуулсан нь Үндсэн хуулийн хэм хэмжээг зөрчсөн байна.” гэжээ.

Хоёр. Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа:



“... Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх...” гэж Улсын дээд шүүхээс бусад шүүхийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр нэрлэснийг Монгол Улсын шүүхийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр нь зохион байгуулж, аймагт аймгийн шүүх, дүүрэгт дүүргийн шүүх оршино гэж тайлбарлан хэрэглэвэл шүүхийн тогтолцоог шүүхийн харьяаллаар сольж, шүүхийн тогтолцоог гажуудуулахад хүргэх юм. Түүнчлэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхээс бусад шүүхийг нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, шийдвэрлэгдсэн хэрэг, маргааны тоог харгалзан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжийг харьяалуулан эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулна.” гэж заасан заалт хүчин төгөлдөр үйлчилж байгаа болно.

Дээрх хуулийн заалтын дагуу Монгол Улсын Их Хурал өөрт хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд Багахангай, Налайх дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, шийдвэрлэгдсэн хэрэг, маргааны тоо, шүүхийн ачааллыг тус тус харгалзан хоёр дүүргийн дунд нэг шүүх байгуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.”, Дөчин долдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Шүүхийг зөвхөн Үндсэн хууль, бусад хуулийн дагуу байгуулна.”, Дөчин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж заасантай нийцсэн гэж үзэж байна. Тухайлбал 2016 онд Нийслэл дэх нэг дүүргийн шүүхэд ногдох хэргийн ачаалал дунджаар Эрүүгийн 276 хэрэг, Иргэний 2899 хэрэг байсан бол Багахангай, Налайх дүүргийн анхан шатны шүүх 2016 онд Эрүүгийн 66, Иргэний 656 хэрэг шийдвэрлэсэн, үүнээс Багахангай дүүрэгт харьяалагдах Эрүүгийн 8, Иргэний 33 хэрэг хянан шийдвэрлэжээ.

Багахангай, Налайх дүүргийн шүүхийн шийдвэрлэсэн нийт 722 хэргээс Багахангай дүүрэгт харьяалагдах 41 хэрэг шийдвэрлэгдсэн байгаа

нь тус шүүхийн өнгөрсөн онд шийдвэрлэсэн нийт хэргийн зөвхөн 5.6 хувийг эзэлж байна. Мөн Багахангай, Налайх дүүргийн шүүхээр 2007-2017 онд шийдвэрлэгдсэн Эрүү, Иргэний нийт 6425 хэргээс Багахангай дүүрэгт харьяалагдах 392 хэрэг байгаа нь Багахангай, Налайх дүүргийн шүүхээр сүүлийн 10 жилд шийдвэрлэсэн нийт хэргийн 6 хувь байна. Үүнээс үзвэл Багахангай дүүрэгт харьяалагдах шүүхээр шийдвэрлүүлсэн хэргийн тоо нэг дүүрэгт ногдох Эрүүгийн хэргийн дундаж тооноос 34 дахин бага, Иргэний хэргийн дундаж тооноос 87 дахин бага байгаа нь тус дүүрэгт бие даасан шүүх байгуулах боломжгүй, эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тодорхой юм.

Түүнчлэн Багахангай дүүрэг нийт хүн амын тоогоор бусад дүүргээс хамгийн бага буюу 4.143 хүн амтай, нутаг дэвсгэрийн хэмжээгээр Нийслэл дэх 9 дүүргээс 7 дугаарт буюу 140.0 км<sup>2</sup> байна.

“Багахангай дүүргийн эдийн засаг, нийгмийн байдал”-ын 2017 оны 3 дугаар улирлын статистикийн танилцуулгад Нийслэл дэх хүн амын нягтрал 1 кв км-т ногдох хотын дундаж 298 хүн байхад Багахангай дүүрэгт хамгийн бага буюу 30 хүнтэй байна. Харин 18-аас дээш насны 10.000 хүнд ногдох гэмт хэргийн тоогоор хотын дундаж 165 хүн байхад Багахангай дүүрэгт 102 хүн байхаар тусгагджээ.

Иймд Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 5 дугаар сарын 13-ны өдөр өөрчлөлт оруулсан Шүүх байгуулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн “Нэг.Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх” гэсэн хэсгийн 8 дахь заалтад “Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх” гэж, мөн зүйлийн “Хоёр.Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх” гэсэн хэсгийн 8 дахь заалтад “Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх” гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн Шүүхийн үндсэн тогтолцооны зохицуулалт болон мөн хуулийн суурь зарчим, үзэл баримтлалыг зөрчөөгүй буюу Цэцээс шийдвэрлэсэн асуудлыг агуулгаар нь дахин сэргээгээгүй байна гэсэн тайлбарыг үүгээр уламжилж байна.” гэжээ.



## ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсын шүүхийн үндсэн тогтолцоог Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэхээр хуульчилсан байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр "... Шүүх байгуулах тухай 1993 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн Монгол Улсын хуулиар Багануур, Багахангай дүүргийн дунд, Баянзүрх, Гачуурт дүүргийн дунд, Сонгинохайрхан, Жаргалант дүүргийн дунд, Хан-Уул, Туул дүүргийн дунд тус бүр нэг шүүх байгуулсан нь нэрийн хувьд "дүүргийн" гэж томъёологдсон боловч үнэн хэрэг дээрээ хоёр дүүргийн дунд нэг шүүх байгуулсан агуулгыг илэрхийлж байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн дүүрэг бүр өөрийн шүүхтэй байх тухай заалтыг зөрчжээ." гэж үзээд 05 дугаар дүгнэлтийг гаргаж, улмаар уг маргааныг эцэслэн шийдвэрлэж 02 дугаартай тогтоолыг гаргасан байна.

Мөн хууль тогтоогчоос 2013 оны Шүүх байгуулах тухай хуулийг батлахдаа шүүхийг шүүн таслах ажлын төрлөөр нь дагнан байгуулж, тэдгээрийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг тогтоохдоо 2-3 аймаг дунд давж заалдах шатны нэг шүүх, 2-3 дүүргийн дунд анхан шатны нэг шүүх байхаар хуульчилсан буюу нэршлийн хувьд дэс дугаарлаж, тойргийн зарчмаар байгуулсан. Харин 2015 оны Шүүх байгуулах тухай хуулиар зөвхөн нэршлийг "аймгийн" болон "дүүргийн" гэж томъёолж, өмнөх хуультай мөн адил 2-3 аймгийн дунд нэг давж заалдах шатны шүүх, 2-3 дүүрэг дунд анхан шатны нэг шүүхтэй байхаар тус тус хуульчилж байсан нь Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шүүхийн үндсэн тогтолцоог зөрчсөн гэж үзэж холбогдох заалтыг хүчингүй болгосон Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 01, 2016 оны 01 дүгээр тогтоол тус тус хүчин төгөлдөр хэвээр байна.

3. Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж

дүүрэг тус бүр нэг шүүхтэй байхаар өөрчлөн найруулсан боловч Шүүх байгуулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн “Нэг.Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх” гэсэн хэсгийн 8 дахь заалтад “Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх” гэж, мөн “Хоёр.Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх” гэсэн хэсгийн 8 дахь заалтад “Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх” гэж хоёр дүүргийн дунд нэг анхан шатны шүүхийг байгуулан хуульчилсан нь дээр дурдсан Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр хүчингүй болсон Шүүх байгуулах тухай хуулийн холбогдох заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн байна.

Үндсэн хуулийн цэцийн тогтоолоор удаа дараа хүчингүй болсон Шүүх байгуулах тухай хуулийн холбогдох заалтыг агуулгаар нь дахин сэргээснээрээ Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэснийг зөрчиж байгааг тэмдэглэх нь зүйтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг; Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг; Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3, 31 дүгээр зүйлийн 2, 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус удирдлага болгон

### **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨЭС ТОГТООХ НЬ:**

1. Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 5 дугаар сарын 13-ны өдөр өөрчлөлт оруулсан Шүүх байгуулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн “Нэг. Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх” гэсэн хэсгийн 8 дахь заалтад “Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх” гэж, мөн “Хоёр.Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх” гэсэн хэсгийн 8 дахь заалтад “Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх” гэж тус тус хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн





цэцийн 1994 оны 02, 2015 оны 01, 2016 оны 01 дүгээр тогтоолоор хүчингүй болсон Шүүх байгуулах тухай хуулийн холбогдох заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн байх тул хүчингүй болгосугай.

2. Энэхүү тогтоолын “Тогтоох” хэсгийн 1 дэх заалтыг 2018 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Энэхүү тогтоол гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

**ДАРГАЛАГЧ**

**Д.ОДБАЯР**

**ГИШҮҮД**

**Н.ЖАНЦАН  
Т.ЛХАГВАА  
Ш.ЦОГТОО  
Д.СУГАР  
Н.ЧИНБАТ  
Д.НАРАНЧИМЭГ  
Д.СОЛОНГО**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 1

**Индекс: 200003**